

**МОНГОЛ-ЯПОНЫ ХАРИЛЦАА:
ЗҮҮН ХОЙТ АЗИЙН
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНД
ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ**

Д. Дүнгэр-Яйчил

Дэлхийн II дайн дуусаад 45 жил болж байна. Түүхийн энэ богино хугацаанд дэлхийн улс төрийн газрын зурагт ихээхэн өөрчлөлт гарав. Үүнтэй уялдан Ази тивийн улс орнуудын дотоод амьдрал гадаад харилцаанд урьд үзэгдээгүй шинэ шинэ өөрчлөлтүүд бий болж, тус бүс нутаг олон улсын улс төр, эдийн засгийн өрсөлдөөний томоохон сорилтын талбай болсоор иржээ. Монгол-Японы харилцаа чухамдаа дээрх үйл явцын бүрэлдэхүүн хэсэг мөн юм.

Өнөөдөр дэлхий дахин бүхэлдээ шилжилт өөрчлөлтийн эрин үед ороод байна. Олон улсын улс төрийн харилцаа цэрэг зэвсгийн сүр хүчинд дулдуйдсан ноцтой сөргөлдөөнөөс гарч, их гүрнүүд харилцан ойлголцох, хамтран ажиллах замд орж тив дэлхийн улс орнууд улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын салбарт үр бүтээлтэй хамтран ажиллах шинэ шинэ зам сувгууд нээгдэж байна.

Олон улсын байдлын ийм таатай нөхцөлд БНМАУ Ази, Номхон далайн (АНД) бүс нутгийн зүүн хойт хэсгийн орнуудтай түүний дотор Япон улстай бүх талын харилцаагаа гүнзгийрүүлэн хөгжүүлж, эдийн засаг болон бусад талын хамтын ажиллагааны цар хүрээгээ алхам алхамаар өргөтгөх нь хоёр орны эрх ашигт нийцэх төдийгүй, манай орнуудын оршин тогтнож байгаа зүүн хойт Азийн энх тайван аюулгүй байдлыг хангахад ч чухал үүрэг гүйцэтгэх юм.

Японы нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн өндөр хөгжил дэвшил нь дайны дараахь хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэнд чухал суурь эзэлж байгаа төдийгүй, улс орны аж ахуй, эдийн засгийг зөв зохион байгуулж чадвал аливаа бэрхшээлийг даван туулж өндөр амжилтад хүрч болохыг хүнд итгэл бишрэл төрүүлэхээр харуулж чадсаныг хэн ч үгүйсгэхгүй.

Энэ нь бидэнд ч сургамжтай жишээ болж чадах тул манай Монгол оронд нийгэм, улс төр, эдийн засгийн шинэчлэл, өөрчлөлтийн ажил эрч далайцтай явж байгаа өнөө үед манай хоёр орны харилцааг богино хугацаанд мэдэгдэхүйц хөгжүүлэх нь олон талын ач холбогдолтой гэдгийг цохон хэлмээр байна. Аливаа улс үндэстэн өөрийн хөгжил дэвшлийн төлөө хэнээс юуг ч сурч болно, сурах ч хэрэгтэй. Үнэнийг нуулгүй хэлэхэд бид олон жилийн турш улс төр, үзэл суртлаар хөөцөлдөж ихээхэн цаг алдаж, дэлхийн хөгжлөөс үлэмж хоцорсон билээ.

Цахим техник хүүхдийн тоглоомд нэвтэрч, лазерийн туяа ахуйн хэрэгцээнд шилжсэн өнөө үед энэ хоцрогдлоос түргэн гарахын төлөө цуцалтгүй тэмцэх нь манай улс үндэстний өмнө тулгарсан нэн чухал зорилго мөн болох тул БНМАУ-ын Засгийн газар (1989 оны 12 дугаар сард) улс төр, эдийн засгийн нээлттэй бодлого хэрэгжүүлэхээ албан ёсоор зарласан билээ.

Олон улсын хамтын ажиллагааны харилцан шүтэлцээ улам нягтарч, улс орнуудын хоорондох итгэлцэл батжиж байгаа орчин үед

ийм бодлого хэрэгжүүлэх нь зөвхөн өөрийн орноор барахгүй, олон улсын харилцааны түүхийн өмнө өндөр хариуцлага хүлээнэ гэсэн үг юм.

Манай улсын засгийн газрын тэргүүн өрнөдийн гүрнүүдийн дотроос хамгийн түрүүнд (1990 оны 2 дугаар сарын хуучдаар) Япон улсад айлчилсан нь БНМАУ-ын нээлттэй бодлогын биелэлийн шууд илрэл мөн бөгөөд манай Засгийн газрын гадаад улс төрийн бодлого, түүний дотор Япон улсын талаар баримтлах бодлогод чанарын өөрчлөлт гарсны баримт даруй мөн юм. Энэ утгаар авч үзвэл тэрхүү айлчлал нь зөвхөн манай хоёр орны харилцааг чанарын шинэ түвшинд гаргаад зогсоогүй бас АНД-н бүс нутгийн зүүн хойт хэсгийн улс орнуудын харилцааны сайжралд зохих нөлөө үзүүлсэн нь дамжиггүй юм. Учир иймд манай орнуудын улс төрийн харилцааг өнө урт хугацаанд тогтвортой байлгах нь юу юунаас чухал юм.

Энэ зорилгыг хангах үүднээс Монгол-Япон хоёр улс зөвхөн худалдаа, эдийн засгийн талаар харилцан ашигтай хамтын ажиллагаатай байгаад зогсох биш улс төрийн талаар ч олон улсын тавцанд хамтран ажиллах хэрэгтэй юм.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга П. Очирбат 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдөр БНМАУ-ын Ардын Их Хурлын Чуулган дээр хэлсэн үгэндээ Ази, Номхон далайн орнуудтай хоёр талын харилцааг тал бүрээр хөгжүүлэхийг Монгол улс чухалчлахыг тэмдэглээд «Тухайлбал, Японтой...харилцааг өргөтгөх талаар нээгдэж байгаа төлөвийг бид үнэлж байгаа бөгөөд энэхүү төлөвийг бодитойгоор хэрэгжүүлэхийн тулд тууштай ажиллах болно» гэж онцлон тэмдэглэв.

Манай улсын Засгийн газраас орчин үед хэрэгжүүлж байгаа гадаад бодлогын нэг онцлог бол бусдын маргаанд оролцохгүй явдал юм. Энэ нь чухамдаа олон улсын бодлогын талаар аль нэг тал руу хэлбийх бус, харин хоёр хөл дээрээ бат зогсоно гэсэн үг даруй мөн билээ. Энэ байр суурь нь БНМАУ-аас Дэлхийн бүх улс орнуудтай харилцах, түүний дотор Ази, Номхон далайн, тухайлбал Монгол-Японы найрсаг харилцаа, хамтын ажиллагааны үндсэн зарчим байх учиртай гэж үзэж байна.

Дэлхий дахины хөгжлийн үйл явц бараг сансрын хурдаар өөрчлөгдөж байгаа өнөөдөр хүмүүс XXI зууны өөдрөг ирээдүйн тухай ярих нь цөөнгүй тохиолддог боллоо. Тэгвэл тийм ирээдүйн тухай, өөрөөр хэлбэл Монгол-Японы харилцааны алс хэтийн тухай сэтгэхдээ «Монгол нь ойрхон атлаа алслагдсан орон» гэж япончуудын ярьдагийг аль аль талдаа анхаарахгүй байж боломгүй санагдаж байна. Зүйр цэцэн үг нь хэн нэгэн хүн амьдралдаа тохиолдсон зовлон жаргалаа дүгнэн хэлсэн үг болох тул япончуудын тэр яриаг газарзүйн ухагдахуун талаас ярьж байна гэж бодоод үзье. Үнэндээ япон хүн Токиогоос мордоод тэр өдөртөө хүрч очиж чадахгүй газар бараг байхгүй. Тэгвэл Монголд ирэхдээ Москва, Бээжингийн аль нэгээр нь дайрсан ч 2-3 хонохоос нааш Улаанбаатарт хүрч ирж чадахгүй. Дэлхийн шинжлэх ухаан, техникийн дэвшил цаг мөчтэй уралдаж байгаа өнөө үед газарзүйн хувьд алслагдсан энэ байдлыг хамтын хүчээр түргэн хугацаанд даван туулах нь зөвхөн манай хоёр орны хувьд төдийгүй Ази, Европын хоорондох зам харилцааны зайг ихээхэн ойр туулах юм.

Дашрамд хэлэхэд хөндлөнгийн элдэв шалтгаанаас болж манай хоёр орны улс төрийн харилцаа ч гэсэн газарзүйн талынхаасаа дутахгүй алслагдаж байсныг нуух хэрэг юун ажээ. Дээр дурдсан зайнуу-

дыг аль болохоор түргэн хугацаанд ойртуулахын тулд манай хоёр орон бололцоотой бүх хүрээнд цаг алдахгүй хамтын ажиллагаагаа хөгжүүлэхийн зэрэгцээ шинэ шинэ санаа санаачлагыг аль аль талаасаа идэвхийлэн гаргах хэрэгтэй гэж бодож байна.

Монгол-Японы хооронд 1972 онд дипломат харилцаа тогтоосноос хойш 18 жил өнгөрлөө. Энэ хугацаанд хоёр талын хамтын чармайлтын үр дүнд худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх талаар ямар нэг хэмжээний амжилт олсон байна. Юуны өмнө хэлэхэд 1977 онд Япон улсын тусламжаар ноолуурын «Говь» комбинатыг байгуулж, уг үйлдвэр ашиглалтад орсноосоо хойш жил бүр эдийн засгийн хувьд ашигтай сайн ажиллаж байна. Монгол ямааны ноолуураар хийсэн бүтээгдэхүүн анх дэлхийн стандартад хүрч олон улсын зах зээл дээр борлолт сайтай бараа болсон нь сайшаалтай хэрэг. Манай хоёр орны хамтын ажиллагааны алхам бүр нь ийм л үр дүнтэй байх ёстой.

Нийгэм, соёлын хэрэгцээнд зориулж Японы Засгийн газрын хөнгөлөлттэй тусламж үзүүлэх юм байна. Төмөр, зэс, цайр боловсруулах үйлдвэр байгуулах асуудлаар хэлэлцээ хийж, бага оврын төмөрлөгийн үйлдвэрийг Японы тусламжтайгаар байгуулахаар тохиролцоод байна. Мөн газрын ховор элементийг ашиглах талаар ярилцаж байна. Манай улс жилдээ 400 зуун мянган тонн зэсийн хүдэр олборлож, 90 гаруй хувийг нь хүдэр хэвээр нь гадаадад гаргаж байна. Хэрэв түүний тэн хагасыг дотооддоо нарийн баяжуулж боловсруулбал жилд 60 мянган тонн зэс үйлдвэрлэх боломжтой болох бөгөөд үлэмж хэмжээний валютын эх үүсвэртэй болох юм.

Японы Иточю пүүс манай талын хүсэлтийг хүлээн авч зэсийн үйлдвэр байгуулах боломжийг судалж байна.

Уул уурхайн салбарт хамтран ажиллах бололцоог хайн сурвалжилж байна.

Мицубиси, Сумитомо, Иточю зэрэг 60 орчим пүүс монголын үйлдвэр, худалдааны газруудтай холбоотой ажиллаж байна. «Жайка»-гийн шугамаар мэргэжилтэн бэлтгэх талаар нэлээд ажил хийж сүүлийн жилүүдэд 80 гаруй хүнийг Японы тал хүлээж авч сургасан байна.

Монгол-Японы хооронд худалдаа хөгжүүлэх протоколд анх 1959 оны 8 дугаар сард Бээжин хотноо гарын үсэг зурж, 1960 оноос худалдаа хийж эхлэв. Гэвч нэлээд удаашралтай байна. Үүнд олон талын шалтгаан байвч гол нь өнгөрсөн хугацаанд манай гадаад худалдааны 90 гаруй хувийг СЭВ-ийн орнууд эзэлж байгаа болохоор манай улс Японоос авах шаардлагатай зүйл их боловч өгөх юмаар хомс байсантай холбоотой юм.

Одоо тус хоёр орны хооронд соёл, шинжлэх ухаан, эдийн засгийн салбарт нэлээд зүйл хийгдэж байна. Япон улс буцалтгүй тусламжийн журмаар эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлж 1990—1991 онд Улаанбаатарын 5 эмнэлэг, дараа нь 7 аймгийн эмнэлгийг тоноглож өгөх юм. Зарим сумдын эмнэлэгт оношлолын лаборатори байгуулж өгөх юм. Үүнд бүгд 400 сая орчим иен зарцуулах ажээ.

Монголын ерөнхий сайд 1990 оны 2 дугаар сарын хуучдаар Японд айлчлах үеэр Японы ерөнхий сайд Кайфутай хэлэлцээ хийж хоёр орны худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны талаар зарим нэг тодорхой асуудлыг шийдвэрлэв. Үүнд: «Монгол-Японы худалдааны хэлэлцээр» байгуулж Японы тал Монголын талд хөнгөлөлт үзүүлэхээр тохиролцов.

Энэ бүхнээс үзвэл Монголын ерөнхий сайдын Японд хийсэн анхны айлчлал ямар нэгэн үр дүнтэй болжээ.

Монгол ардын зүйр цэцэн үгэнд «Чамлахаар чанга атга» гэж

байдаг. Монгол-Японы харилцааны ахиц ололтыг чамлахыг хүсэхгүй байна. Гэвч өргөн дэлгэр нутагтай Монгол, өндөр хөгжилтэй Япон хоёр хамтран хийчихээр ажил их байна. Тийм бололцоо ч байна. Жишээ нь Японы олон улсын шуурхай шуудан «Таккюбин»-ы дамжих баазыг Монголд байгуулж болох юм. Ингэснээр бөмбөрцгийн өрнөд дорнодын хоорондох агаарын харилцааны туулах замыг богиносгож болох төдийгүй, далайд гарцгүй манай орны байдлыг ямар нэг хэмжээгээр хөнгөлж болох байна.

Үүнийг зүгээр нэг мөрөөдөл болгож хэлж байгаа хэрэг огт бишээ. Олон улсын эдийн засгийн харилцааны өөр хоорондын шүтэлцээ өдрөөс өдөрт хүчтэй болж байгаа өнөө үед улс орнуудын хамтын ажиллагаа зохицолдоо сайтай байх нь нэн чухал юм. Учир иймд энэ талаархи судалгаа шинжилгээний ажлыг бүс нутгийн орнуудын эрдэмтдийн хамтын хүчээр явуулах нь орон тус бүрээр барахгүй, тив дэлхийн аль алины нь байр сууринаас авч үзэхнээ ч эрин цагийн ач холбогдолтой юм. Ингэж хамтран ажиллавал бүс нутгийн эдийн засгийн болон бусад салбар дахь хамтын ажиллагаа нь дэлхий дахины нийт хөгжилд зохицох чадвар сайтай болох юм.

Одоо Монгол улсын эдийн засаг эргэлтийн шинэ үед ороод байна. Манай улс хөнгөн, хүнсний үйлдвэрийг цаашид хөгжүүлэхийн зэрэгцээ орчин үеийн техник, технологи төвлөрсөн аж үйлдвэрийн салбаруудыг хөгжүүлэх зорилго тавьж байгаагийн дээр хоршооллын үйлдвэр, аж ахуйг хөгжүүлэх, гадаадын капиталтай улс, иргэд аль алин нь хамтран ажиллахыг хуулиар бататгаж өгөв.

Манай улсын Засгийн газар зах зээлээр зохицуулах эдийн засгийн бодлого хэрэгжүүлэх чиглэл баримталж байгаа нь тус орны эдийн засгийн амьдрал нь зөвхөн улс орны дотоодод гарч байгаа өөрчлөлтөд зохицох чадвартай байх төдийгүй олон улсын эдийн засгийн амьдралын өөрчлөлтөд зохицох чадвар нь аяндаа дээшлэх нь мэдээж юм. Энэ бүхэн нь бусад орнуудтай хамтран ажиллах шинэ нөхцөл бололцоог бий болгож байгаа гэдгийг манай оршин тогтнож байгаа бүс нутгийнхан төдийгүй дэлхийн бусад бүс нутгийн улс орнууд ч анхааран үзэх нь зүйтэй болов уу. Олон улсын амьдрал бүхэлдээ өөрчлөлт шинэчлэлтийн замд орж, БНМАУ-ын гадаад бодлогод улс төрийн шинэ шинэ уур амьсгал алхам бүрд харагдах болсон орчин үед Монгол-Япон хоёрын харилцаанд нөлөөлөх хөндлөнгийн хүчин зүйлүүд улам цөөрсөөр байгааг Япон түншүүд маань анхааран үзэх нь зүйтэй мэт санагдах юм.

Шинэ, хуучин аль ч сэтгэлгээгээр авч үзсэн ч «цаг бол алт» юм. Дээр өгүүлсэнчлэн бид улс төртэй Хэт зууралдаж ихээхэн цаг алдсантай адил манай япон түншүүд тийм алдаанд хүрэхгүй гэдэгт найдаж байна.

Үүнтэй холбогдуулан хэлэхэд Японы ерөнхий сайд Кайфу 1990 оны 3 дугаар сарын 2-нд өөрийн программын үгэндээ АНД-н бүс нутгийн улс төрийн тогтвортой байдлыг хангаж, эдийн засгийг хөгжүүлэх нь Японы туйлын чухал зорилт гэж тэмдэглэв. Энэ утгаар авч үзвэл Монгол-Японы харилцаа цаашид ямаршуухан чиглэлээр хөгжих нь Японы талын байр сууринаас шалтгаалах зүйл цөөнгүй байна.

Төгсгөлд нь Ази, Номхон далайн бүс нутаг, түүний зүүн умарт хэсгийн хүчний харьцааны тухай ярихдаа БНМАУ, БНАСАУ-ыг оролцуулан авч үзэх нь зайлшгүй шаардлагатай.

Ингэвэл тус бүс нутгийн 5 орны харилцааг бүрэн хэвийн байдалд оруулах хамтын чармайлт илүү үр дүнд хүрэх бөгөөд бүх талын хамтын ажиллагаа ч ахиц сайтай байх болно.